



МОНГОЛ УЛСЫН
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

Ц. Нацагдорж 50.
В.Г.М.М.М.

1999 оны 08-р сарын 11 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг суралцуулах тухай

Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцах хүмүүс сонгон шалгаруулах 1999 оны уралдаант шалгалтын дүн, Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцагчдыг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах ажлыг хариуцсан комиссын 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн А / 122 дугаар тушаалыг үндэслэн Цэрэндоржийн Нацагдоржийг эрүүл мэндийн санхүүжилтын, Жанчивын Хуланг эмгэг судлалын, Үндэсний статистикийн газрын даргын 1999 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 103 дугаар тушаалыг үндэслэн Элдэв-Очирын Эрдэнэчимэгийг статистикийн, Улсын аюулгүй байдлыг хангах газрын даргын 1999 оны 5 дугаар сарын 21 - ний 164 дүгээр тушаалыг үндэслэн Наранцогтын Баатархуягийг мэдээлэл зүйн, Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 1999 оны 7 дугаар сарын 27-ны 07/143 дугаар тушаалыг үндэслэн Дамбын Лхагвасүрэнг олон улсын эдийн засгийн, Гэгээрлийн яамны нэр дээр Ишдоржийн Эрдэнийг боловсролын удирдлагын, Гончигийн Болормааг биологийн, Цэдэндоржийн Гантулгыг математикийн мэргэжлээр АНУ-ын Денвер хотын Колорадагийн их сургуулийн магистрантурт тус тус суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам" -ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулан холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан / Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

А.БАТТОР